ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

# Онги-Таац голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2022/115/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: atjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ө.Ринчинмядаг
Утас: 70323108 Цахим хаяг: rinchinmyadagu@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3.Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
3.8 Аудитын гол асуудал ........ 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
4.1 Залруулсан алдаа ........ 14
4.2 Төлбөрийн акт ........ 14
4.3 Албан шаардлага ........ 14
4.4 Зөвлөмж ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 14

## 1.Аудитын гэрчилгээ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.21 № 54

танай ____________-ны №____________-т

ОНГИ-ТААЦ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
С.ДУЛАМРАГЧАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онги-Таац голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онги-Таац голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

015030109

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,266,410.00 | 3,533,050.00 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | - | 0.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | 0.00 |
| 3121 | Төгрөг | - | 0.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 0.00 |
| 33 | АВЛАГА | 32,110.00 | - |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 32,110.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,234,300.00 | 3,533,050.00 |
| 354 | Хангамжийн материал | 2,234,300.00 | 3,533,050.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 96,500.00 | 299,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,137,800.00 | 2,299,000.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 934,350.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 69,626,524.28 | 51,762,776.60 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 69,626,524.28 | 51,762,776.60 |
| 392 | Биет хөрөнгө | 69,296,524.28 | 51,597,776.60 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 58,227,073.78 | 58,227,073.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (7,814,940.80) | (17,584,769.72) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 19,409,137.56 | 19,409,137.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (5,953,849.76) | (12,711,837.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,879,311.18 | 10,879,311.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,450,207.68) | (6,621,138.64) |
| 393 | Биет бус хөрөнгө | 330,000.00 | 165,000.00 |
| 39301 | Програм хангамж | 330,000.00 | 330,000.00 |
| 39302 | Хасагдуулга | - | (165,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 71,892,934.28 | 55,295,826.60 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 71,892,934.28 | 55,295,826.60 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 71,892,934.28 | 55,295,826.60 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 71,892,934.28 | 55,295,826.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 71,892,934.28 | 71,892,934.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (16,597,107.68) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 71,892,934.28 | 55,295,826.60 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 213,170,503.78 | 142,444,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 68,804,717.78 | 00.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 68,804,717.78 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 68,804,717.78 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 68,804,717.78 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 144,365,786.00 | 142,444,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 143,651,500.00 | 141,545,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 143,651,500.00 | 141,545,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 714,286.00 | 899,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 714,286.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 899,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 155,899,121.94 | 159,041,607.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 155,899,121.94 | 159,041,607.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 148,890,130.76 | 139,621,429.22 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 92,000,672.00 | 81,793,966.00 |
| 210101 | Үндсэн цалин | 72,009,857.00 | 60,749,258.00 |
| 210102 | Нэмэгдэл | 16,218,084.00 | 14,810,608.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,772,731.00 | 6,234,100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,295,836.82 | 11,073,238.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,422,935.37 | 7,767,985.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 980,400.00 | 857,814.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 753,188.13 | 652,651.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 196,100.00 | 163,160.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,943,213.32 | 1,631,627.26 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,826,000.00 | 8,724,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,826,000.00 | 8,724,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,744,300.00 | 6,562,331.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 417,600.00 | 895,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,254,500.00 | 2,751,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,446,656.00 | 1,209,031.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,625,544.00 | 798,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 908,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,591,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,591,000.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 239,300.00 | 157,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 239,300.00 | 157,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,165,000.00 | 2,637,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,165,000.00 | 2,637,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,676,376.00 | 8,530,345.89 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,839,266.00 | 8,131,245.89 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 69,300.00 | 69,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 66,010.00 | 60,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,800.00 | 19,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,351,645.94 | 20,142,347.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 216,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,652,200.00 | 2,062,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,699,445.94 | 17,863,747.68 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,008,991.18 | 19,420,178.46 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,008,991.18 | 19,420,178.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,008,991.18 | 19,420,178.46 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 57,271,381.84 | -16,597,107.68 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 57,271,381.84 | -16,597,107.68 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 144,365,786.00 | 142,444,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 144,365,786.00 | 142,444,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 143,651,500.00 | 141,545,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 143,651,500.00 | 141,545,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 714,286.00 | 899,100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 714,286.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 899,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 144,365,786.00 | 142,444,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 144,365,786.00 | 142,444,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 137,356,794.82 | 123,024,321.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 92,032,782.00 | 81,761,856.00 |
| 210101 | Үндсэн цалин | 72,041,967.00 | 60,717,148.00 |
| 210102 | Нэмэгдэл | 16,218,084.00 | 14,810,608.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,772,731.00 | 6,234,100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,295,836.82 | 11,073,238.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,422,935.37 | 7,767,985.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 980,400.00 | 857,814.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 753,188.13 | 652,651.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 196,100.00 | 163,160.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,943,213.32 | 1,631,627.26 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,826,000.00 | 8,724,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,826,000.00 | 8,724,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,799,800.00 | 6,791,081.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 455,100.00 | 1,098,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,242,500.00 | 3,685,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,446,656.00 | 1,209,031.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,655,544.00 | 798,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 641,500.00 | 640,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 641,500.00 | 640,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 267,300.00 | 267,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 267,300.00 | 267,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,165,000.00 | 2,637,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,165,000.00 | 2,637,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,676,376.00 | 8,530,345.89 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,839,266.00 | 8,131,245.89 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 69,300.00 | 69,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 66,010.00 | 60,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,800.00 | 19,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,652,200.00 | 2,598,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 216,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,652,200.00 | 2,382,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,008,991.18 | 19,420,178.46 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,008,991.18 | 19,420,178.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,008,991.18 | 19,420,178.46 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 14,621,552.44 | 00.00 | 14,621,552.44 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **14,621,552.44** | **00.00** | 14,621,552.44 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 55,903,583.37 | 00.00 | 55,903,583.37 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **71,892,934.28** | **00.00** | 71,892,934.28 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **71,892,934.28** | **00.00** | 71,892,934.28 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **71,892,934.28** | **00.00** | 71,892,934.28 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -16,597,107.68 | 00.00 | -16,597,107.68 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **55,295,826.60** | **00.00** | 55,295,826.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 143,651,500 | 136,642,509 | 141,545,400 | 122,125,222 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 143,651,500 | 136,642,509 | 141,545,400 | 122,125,222 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 143,651,500 | 136,642,509 | 141,545,400 | 122,125,222 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 98,031,700 | 92,032,782 | 98,031,700 | 81,551,856 |
| 210101 | Үндсэн цалин | 77,949,500 | 72,041,967 | 73,654,400 | 60,717,148 |
| 210102 | Нэмэгдэл | 16,308,800 | 16,218,084 | 18,013,400 | 14,810,608 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,773,400 | 3,772,731 | 6,363,900 | 6,024,100 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,234,500 | 12,295,837 | 13,234,300 | 11,073,239 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,313,000 | 8,422,935 | 9,313,000 | 7,767,985 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 980,400 | 980,400 | 980,300 | 857,814 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 784,300 | 753,188 | 784,300 | 652,651 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 196,100 | 196,100 | 196,100 | 163,161 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,960,700 | 1,943,213 | 1,960,600 | 1,631,627 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,826,200 | 8,826,000 | 8,724,200 | 8,724,000 |
| 210304 | Байрны түрээс | 8,826,200 | 8,826,000 | 8,724,200 | 8,724,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,085,600 | 7,085,514 | 6,318,600 | 6,318,581 |
| 210401 | Бичиг хэрэг | 455,100 | 455,100 | 628,300 | 1,098,250 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,242,500 | 4,242,500 | 3,213,300 | 3,213,300 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,446,700 | 1,446,656 | 1,679,000 | 1,209,031 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 941,300 | 941,258 | 798,000 | 798,000 |
| **2105** | **Нормативт зардал** | 641,500 | 641,500 | 640,000 | 640,000 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 641,500 | 641,500 | 640,000 | 640,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 267,300 | 267,300 | 267,300 | 267,300 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 267,300 | 267,300 | 267,300 | 267,300 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,165,000 | 3,165,000 | 2,638,000 | 2,637,900 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,165,000 | 3,165,000 | 2,638,000 | 2,637,900 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,747,500 | 9,676,376 | 9,309,300 | 8,530,346 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,910,200 | 8,839,266 | 8,910,200 | 8,131,246 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000 | 432,000 | 00 | 00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 69,300 | 69,300 | 69,300 | 69,300 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 66,200 | 66,010 | 60,000 | 60,000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,800 | 19,800 | 19,800 | 19,800 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000 | 250,000 | 250,000 | 250,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,652,200 | 2,652,200 | 2,382,000 | 2,382,000 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,652,200 | 2,652,200 | 2,382,000 | 2,382,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 143,651,500 | 143,651,500 | 141,545,400 | 141,545,400 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 143,651,500 | 143,651,500 | 141,545,400 | 141,545,400 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 143,651,500 | 143,651,500 | 141,545,400 | 141,545,400 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 09 | 09 | 09 | 09 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 06 | 06 | 07 | 07 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02 | 02 | 01 | 01 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 899,100.00 | 714,286.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 899,100.00 | 714,286.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 899,100.00 | 714,286.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 210,000.00 | |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 210,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 472,500.00 | 714,286.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 472,500.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 714,286.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 216,600.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 216,600.00 | 00.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 899100.00 | 714286.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 899,100.00 | 714,286.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 899,100.00 | 714,286.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Онги-Таац голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор аудитор Ө.Ринчинмядаг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.10-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалж, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг сав газрын хэмжээнд хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Онги-Таац голын сав газрын захиргааны дотоод хяналтын нэгж нь ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдээс бүрдсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй.

Жил бүр дотоод хяналт шалгалтын явуулах ажлын төлөвлөгөөг гарган тайлагнадаг бөгөөд дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, илэрсэн зөрчил дутагдлыг ариглах зөвлөмжийг тухай бүрд нь өгч, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онги-Таац голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлыг үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 159.04 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.59 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.27 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд үнэ төлбөргүй нэмэгдсэн үндсэн хөрөнгө, бараа материал байхгүй. Материаллаг хэмжээний өөрчлөлттэй үндсэн хөрөнгө, бараа материал байхгүй болно.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 141.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжихээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 5.1 хувиар буурсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 122.1 сая төгрөгөөр санхүүжигдэн, 122.1 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 0.899 сая төгрөгийг цалин хөлс болон бусад нөхөн олговор, тээвэр, шатахуун, бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин байгууллагын ажилчдад 640.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг байршуулахаас 149 мэдээллийг олон нийтэд бүрэн мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгө зарцуулсан тушаал, шийдвэрийн мэдээлэл шилэн дансанд байршуулаагүй зөрчлийг бүрэн арилгасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.64 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Байгууллагын ажилчдад 640.0 мянган төгрөгөөр ажлын хувцас худалдан авсан.

### 4.4 Зөвлөмж

Байр болон грашны түрээсийн гэрээг байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байна.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Онги-Таац голын сав газрын захиргаа | 2 | 0.64 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0.64 | 1 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Ө.РИНЧИНМЯДАГ

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР